



## Олон улсын Эмэгтэйчүүдийн Өдөрт Монгол улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллага

### Ялгавартай байдлын арилгая, эрх тэгш байдлыг дэмжье

**Монгол улс, Улаанбаатар хот (2016 оны 3-р сарын 7)** – Ядүүрлыг арилган тэгш бус байдлыг бүүруулах үйл ажиллагаа эмэгтэйчүүдийг дэмжихээс эхэлдэг. Энэ жилийн хувьд Олон улсын Эмэгтэйчүүдийн өдөр **“2030 он хүртэл дэлхийд 50-50: Жендэрийн тэгш байдлыг дэмжих нь”** уриан дор явагдаж байна. Жендэрийн тэгш байдлыг хангах асуудал нь 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн хөтөлбөрийн салшгүй хэсэг бөгөөд өнөөдөр бид энэхүү үйл ажиллагааг үр дүнд хүргэхийн тулд улам шаргуу ажиллах хэрэгтэйг цохон тэмдэглэж байна.

Монгол улсад эмэгтэйчүүдийн нийгэмд гүйцэтгэх үүргийг дээшлүүлэхэд тодорхой ахиц дэвшил гарсан ч эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих, шийдвэр гаргах түвшинд тэгш байдлыг хангах, ажил эрхлэлтэд жендэрийн тэгш байдлыг хангах болон охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг арилгах зэрэг асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Монгол улсын парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь 14.5 байгаа нь дэлхийн дундаж 22.9 хувь, Ази, Номхон далайн улс орнуудын дундаж 18.8 хувиас доогуур үзүүлэлт юм. Саяхан эмэгтэй нэр дэвшигчдийн квотыг 30 хувь болгосон нь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлж байна. Удахгүй болох Улсын Их Хурлын сонгууль нь сонгогчид болон улс төрийн намуудад эмэгтэйчүүдийг дэмжих боломжийг олгож байна.

Хөдөлмөрийн зах зээл дээрх жендэрийн тэгш бус байдал нь шийдвэрлэх зохистой асуудал юм. Тухайлбал эмэгтэйчүүд дээд боловсрол эзэмших нь илүүтэй байдаг ч авч буй цалин нь дунджаар эрэгтэйчүүдийн цалингийн 85 хувьтай л тэнцдэг. Эмэгтэйчүүд нь мэргэжил болон үр чадвараасаа үл хамааран ихэнхдээ бага цалинтай ажил эрхэлж байгаа бөгөөд төр, хувийн хэвшлийн байгууллагуудад эрэгтэйчүүдээс доогуур албан тушаалд ажиллаж байна.

Монголын эмэгтэйчүүд эрчүүдтэй харьцуулахад хоёр дахин илүү хугацааг ар гэрийн ажил, хүүхдээ асрахад зарцуулдаг. Иймэрхүү төрлийн ажлыг дэмжих нийгмийн тогтолцоо нөхцөл хангалтгүй учир эмэгтэйчүүд эсвэл ажил эрхлэх, эсвэл гэр бүлээ сонгох, эсвэл аль

алиныг нь нэгэн зэрэг хийх сонголттой тулгардаг нь эмэгтэйчүүдийг эдийн засгийн өндөр үр бүтээлтэй, өндөр цалинтай ажил эрхлэх, өндөр албан тушаалд дэвших, нийгмийн амьдралд идэвхтэй оролцоход саад бэрхшээл болж байна. Энэ нь бусад орны адил “шилэн тааз” “наалдамхай шал” гэсэн нийтлэг бэрхшээл Монгол эмэгтэйчүүдэд ч тулгарч байгааг харуулж байгаа бөгөөд үүнийг даруй шийдвэрлэх хэрэгтэй байна.

Монгол улсад охид эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөх явдал түгээмэл байгаа бөгөөд таван эмэгтэйн нэг, хоёр хүүхдийн нэг нь гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг гэсэн мэдээлэл байна. Статистикийн судалгаанаас үзэхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийн 88 хувь нь эмэгтэйчүүд, 40 хувь нь 15-34 насны залуу охид бүсгүйчүүд байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь хүний эрхийг зөрчиж байгаа явдал бөгөөд үүнийг зогсоох арга хэмжээг авах шаардлагатай.

**“2030 он хүртэлх Дэлхий 50-50”** уриа нь зөвхөн эмэгтэйчүүдийн төлөө уриа биш бүх нийгмийг жендэрийн тэгш эрхийн төлөө ажиллахыг уриалсан хөтөлбөр юм. Дэлхийн олон нийт, нийгмийн анхаарлыг жендэрийн тэгш байдлыг хангах асуудалд хандуулах зорилготой Олон улсын Эмэгтэйчүүдийн Өдөр нь 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах нь дамжиггүй.

\*\*\*